ВИДЕО МЭДЭЭ · 2023 оны 2-р сарын 17

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ 2023 ОНЫ НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО



Монгол Улсын Прокурорын байгууллагын удирдах ажилтны 2023 оны нэгдсэн зөвлөгөөн 2 дугаар сарын 13-ны өдрөөс 15-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа.

Зөвлөгөөнөөр прокурорын байгууллагаас 2022 онд хийсэн ажил, хүрсэн үр дүн болон "Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хэрэгжүүлэхэд баримтлах бодлого чиглэл, авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээний талаар хэлэлцлээ.

Энэ удаагийн нэгдсэн зөвлөгөөний арга хэмжээнд Монгол Улсын үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат, Монгол Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг болон Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн Үндэсний комиссын холбогдох албан тушаалтнууд хүрэлцэн ирж мэдээлэл хийлээ.

Зөвлөгөөний төгсгөлд Монгол Улсын ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан нийт прокурор, ажилтнуудад үүрэг даалгавар өгч, 2022 онд амжилттай ажиллаж, бусдыгаа манлайлсан Сүхбаатар, Увс аймаг, Сонгинохайрхан

дүүргийн прокурорын газруудыг болон Хөвсгөл аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор Н.Батмөнх, Баянгол дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор С.Гансэлэм, Хан-Уул дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор О.Алтангэрэл нарыг шагнаж, урамшууллаа.

Видео: https://www.youtube.com/watch?v=e6OZ2VerQio

Прокурорын байгууллага 2023-2026 онд:

- ОЛОН НИЙТЭД ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛААР СУРТАЛЧЛАН ТАНИУЛЖ, ЭРЭГ ХАНДЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ,

- Прокурорын үйл ажиллагааны хараат бус, бие даасан байдлыг хангах,

- ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН АЖЛЫН ЧАНАР, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛЖ, БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ,

- ХАМТ ОЛНЫ ДУНД ЭРЭГ ХАНДЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ САЙЖРУУЛАХ,

- ЦАХИМ ШИНЭЧЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАМААР АЖЛЫН БҮТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ стратегийн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1730